

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ
7 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдөр хуралдаж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус хуралдааны товыг тогтоох тухай асуудлыг хэлэлцэж коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөхцөл байдлын улмаас 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдөр хуралдуулахаар товлосон тогтоолд өөрчлөлт оруулж 2021 оны 7 дугаар сарын 20-ны өдөр хуралдуулахаар шийдвэрлэсэн.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааны шийдвэрийн дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус хуралдаан 2021 оны 7 дугаар сарын 20-ны өдөр хуралдаж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нэр бүхий төлөөлөгчдийн өргөн мэдүүлснээр аймгийн Засаг даргыг огцруулах тухай асуудлыг хэлэлцсэн.

Хуралдаанд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 21 төлөөлөгч оролцож 53.8 хувийн ирцтэйгээр хуралдаж аймгийн Засаг даргыг огцруулах саналыг хуралдаанд оролцсон 21 төлөөлөгчөөс 20 төлөөлөгч дэмжиж, 1 төлөөлөгч дэмжээгүй бөгөөд 95.2 хувийн саналаар аймгийн Засаг даргыг огцруулах шийдвэр гаргаж Монгол Улсын Ерөнхий сайдад уламжлахаар шийдвэрлэсэн байна.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл 2021 оны эхний хагас жилд 28 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас 71.562000 төгрөгийг зарцуулж, төлөвлөгөөний биелэлт 58 хувьтай байна.

Мөн аймгийн Онцгой байдлын газартай хамтран үер усны ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 8 төрлийн сургалт сурталчилгаа, эргүүл хяналтын арга хэмжээг зохион байгуулж 2.250000 төгрөгийг зарцуулсан байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

Аймгийн Засаг даргын 2021 оны А/143 дугаар захирамжаар баталсан “Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумын Засаг дарга, ЗДТГ-ын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу агентлаг, сумдын 2021 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, зөвлөмж хүргүүлсэн.

Архангай аймагт сүүлийн 24 цагт (7 дугаар сарын 29) 241 хүнд PCR шинжилгээ хийгдсэнээс 20 тохиолдол, 82 хүнд түргэвчилсэн оношлуураар шинжилгээ хийгдсэнээс 15 тохиолдол батлагдаж, нийт 323 шинжилгээнээс шинээр илэрсэн тохиолдол 35 байна. Үүнд: Батцэнгэл 7, Хайрхан 1, Чулуут 3, Ихтамир 1, Тариат 1, Хашаат 2, Өндөр-Улаан 1, Эрдэнэбулган 19 байна.

Архангай аймагт коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын халдварын батлагдсан нийт тохиолдлын тоо 2476 боллоо. Сумдаар нь авч үзвэл, 2020 онд Батцэнгэл 3, 2021 онд Батцэнгэл 26, Хайрхан 95, Эрдэнэмандал 69, Чулуут 73, Ихтамир 129, Цэнхэр 115, Хотонт 92, Тариат 114, Өлзийт 110, Жаргалант 52, Өгийнуур 43, Хашаат 114, Өндөр-Улаан 69, Төвшрүүлэх 53, Хангай 31, Цахир 16, Хоршоолол 8, Эрдэнэбулган 1237, Цэцэрлэг 22, Булган 5 байна.

Аймгийн хэмжээнд дэлгэсэн тусгай эмнэлэг 23, дэлгэсэн ор 660, коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын халдварын улмаас нийт эмчлүүлж байгаа хүн 291,

эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй эмчлүүлэгч 217, ӨЭМТ-ийн хяналтанд гэрээр эмчлэгдэж байгаа хүн 74, эмчлэгдэн гарсан хүний 2182 (88.1хувь) байна.

Улсын Онцгой комиссын 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 21 дүгээр хурлын тэмдэглэл, аймгийн Онцгой комиссын 2021 оны 16 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” аймгийн Засаг даргын захирамж гарч аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэг “Улаан түвшин”-д 2021 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 07.00 цагаас 7 дугаар сарын 10-ны өдрийн 07.00 цаг хүртэл хугацаанд шилжүүлж, Засгийн газрын 2021 оны 118 дугаар тогтоолоор баталсан “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-д заасан арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг агентлаг, байгууллагын удирдлагууд, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосон.

Аймаг, орон нутгийн хэмжээнд коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын халдвараар өвчилсөн иргэдийг аймгийн Нэгдсэн эмнэлгийн 120 ортой тусгайлсан эмнэлэгт тусгаарлан эмчилгээ хийж байна. Халдвар авсан иргэдийн ойрын болон дам хавьтлуудыг тандалт судалгаа хийж илрүүлэн PCR шинжилгээ авч, гэрээр тусгаарлан, биеийн байдал тогтворгүй, шинж тэмдэг нь сэжигтэй тусгаарлах зайлшгүй шаардлагатай иргэдийг тусгаарлан ажиглах байранд 7-14 хоног байрлуулж 2-3 удаагийн давтан шинжилгээ авч шинжилгээний хариуг үндэслэн хариу арга хэмжээг авч ажиллаж байна.

2021 оны 7 дугаар сард коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд Засгийн газрын тогтоол, Улсын Онцгой комиссын даргын тушаал, хурлын тэмдэглэл, албан даалгавар, аймгийн Онцгой комиссын хурлын тэмдэглэл, аймгийн Засаг даргын захирамжаар “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-ээс “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжин аймаг, орон нутгийн хэмжээнд хөдөлгөөний хязгаарлалт хийж, зарим байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хязгаарлалт хийн аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар хяналт тавьж, бусад төрийн байгууллагуудын ажилтан, албан хаагч нартай хамтран аймгийн Шуурхай штаб, хяналтын постонд 24 цагийн үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд мөрдүүлэх, хүн хоорондын зай бариулах, амны хаалт тогтмол зүүлгэх, ариутгал, халдваргүйжүүлэлт, агаар сэлгэлт тогтмол хийлгэх, халуун хэмжих, QR код уншуулж бүртгүүлэх талаар Эрдэнэбулган суманд үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний дэлгүүрүүд, худалдааны төвүүд болон төрийн байгууллагуудын нийт 5000 гаруй ажилтан, албан хаагч, иргэдэд заавар, зөвлөмжийг өгч, аж ахуйн нэгжийн ариутгал, халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээ үйлчилгээнд хяналт тавьж, иргэд олон нийтийг амны хаалт зүүхийг уриалж ажилласан.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг аймгийн хэмжээний орон сууц, зах худалдааны төв, гудамж хорооллын оршин суугч, иргэдэд 190 удаа автомашинаар болон аймгийн төвд байрлах чанга яригчтай дуут дохиогоор хүргэж ажилласан. Аймгийн Шуурхай штабын гишүүд сум болон Улсын Онцгой комиссын Шуурхай штабтай цахим хурал, сургалтыг 2 удаа зохион байгуулсан.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд Татвар төлөлт

2021 оны 7 дугаар сард орлогын төлөвлөгөөг хүлээгдэж буй гүйцэтгэлээр улсын төсөвт 163.9 сая төгрөг, аймгийн төсөвт 890.9 сая төгрөг төвлөрүүлэхээр ажиллаж байна. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 972, хувь хүний орлогын албан татварын 1240, бусад төлбөр хураамжийн 112 тайланг цахимаар хүлээн авлаа.

Хөрөнгө оруулалт

2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 41.177.4 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 45 төсөл арга хэмжээ батлагдсанаас 2021 оны 6 дугаар сарын байдлаар 2.548.437.0 мянган төгрөг, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3.666.2 мянган төгрөгийн 28 төсөл, арга хэмжээ батлагдсанаас 2021 оны 6 дугаар сарын байдлаар 283.826.2 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Авто замын сангийн хөрөнгөөр 315.0 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр тус тус батлагдсан байна.

Орон нутгийн өмч, худалдан авах ажиллагаа

Орон нутгийн өмчит 27 төсөвт байгууллагад 49.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авах, 5 төсөвт байгууллагад 27.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэх, 21 байгууллагад 358 нэр төрлийн 351.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил актлах зөвшөөрлийг тус тус олгосон.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 12 дугаар тогтоолоор хувьчлахаар шийдвэрлэсэн үл хөдлөх хөрөнгийн нийтийн дуудлага худалдааг 2021 оны 7 дугаар сарын 6-ны өдөр зохион байгуулж, 1 барилгыг дуудлага худалдаагаар худалдаж, орон нутгийн төсөвт 2.5 сая төгрөг төвлөрүүлэхээр болсон.

2021 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 100.0 сая төгрөгний 1 төсөл арга хэмжээ, Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 130.0 сая төгрөгний 1 төсөл арга хэмжээ, Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл, сумын орон нутгийн хөгжлийн сантай хамтарсан 348.2 сая төгрөгний 1 төсөл арга хэмжээ, Орон нутгийн хөгжлийн сангийн 769.0 сая төгрөгний 7 төсөл арга хэмжээ, Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжих 30.0 сая төгрөгний өртөг бүхий 1 төсөл арга хэмжээ, Захиалгат ажил 1.337.0 сая төгрөгний 2 төсөл арга хэмжээний худалдан авалтыг тус тус зохион байгуулан, тендер зарлаж, цахим системд байршуулсан.

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих 1.600.0 сая төгрөгний өртөг бүхий Эрдэнэбулган сумын 2-р цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн ажил, Өндөр-Улаан, Чулуут сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах 160.0 сая төгрөгний зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг хүргүүлсэн.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 901.2 сая төгрөгний өртөг бүхий 5 төсөл арга хэмжээний ажлын тендерт нэг ч аж ахуйн нэгж тендер ирүүлээгүй тул дахин зарласан. Мөн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих Өгийнуур сумын Орхон голын модон гүүр барих ажлын тендерийг 2 удаа зарласан боловч нэг ч аж ахуйн нэгж тендер ирүүлээгүй тул хуулийн дагуу захиалагчид зөвлөмжийг хүргүүлсэн.

Санхүүгийн хяналт

Сангийн сайдын баталсан нэгдсэн удирдамжийн хүрээнд аймгийн Татварын хэлтсийн 2019, 2020 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдэж, 104.7 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг чиглэл өгч ажиллалаа.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

Хууль, хяналт

2021 оны 7 дугаар сард аймгийн Онцгой байдлын газарт нийт 37 дуудлага мэдээлэл ирснээс үер усны дуудлага 32 удаа, гол, нуурын усанд унаж осолдсон дуудлага 1 удаа, гал түймрийн зөрчлийн дуудлага 4 удаа тус тус ирсэн байна. Уг дуудлагаар Онцгой байдлын газар болон сум орон нутгаас давхардсан тоогоор 241 алба хаагч, ажилтан, 52 техник хэрэгсэлтэйгээр үүрэг гүйцэтгэж 203 хүний амь нас, 126 гэр, малын хашаа саравч, 24 автомашин техник хэрэгслийг авран хамгаалж ажилласан байна.

Онцгой байдлын ерөнхий газрын тэргүүн дэд дарга бөгөөд шуурхай штабын даргын өгсөн үүргийн дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутаг дэвсгэрт байршилтай коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын халдвартай иргэдийг хүлээн авч байгаа улсын болон хувийн хэвшлийн эмнэлэг, эрүүл мэндийн төв болон өрхийн эмнэлгүүдэд ашиглагдаж буй бэсрэг хүчилтөрөгчийн үйлдвэр, баллон хадгалах, цэнэглэх, түгээх байрууд, хүчилтөрөгчөөр хангаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын хүчилтөрөгчийн үйлдвэрүүдийн барилга байгууламжид гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 2021 оны 7 дугаар сарын 22-ны өдрөөс 23-ны өдрийн хугацаанд зохион байгууллаа.

Шалгалтад аймгийн Нэгдсэн эмнэлгийн Эх хүүхдийн нөхөн үржихүйн клиник, Сэхээн амьдруулах тасаг, Хүчилтөрөгчийн баллон хадгалах агуулах, Коронавирусын халдвартай иргэдийг хүлээн авч байгаа тусгаарлан эмчлэх байр гэсэн 1 байгууллагын 5 объект хамрагдаж Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, норм, стандартын холбогдох заалтыг зөрчсөн 24 зөрчил илрүүлж 6 зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулан бусад зөрчлүүдийг арилгуулахаар Гамшгаас хамгаалах болон Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага бичиж байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хүргүүлээ. Мөн хяналт шалгалтын хугацаанд тус байгууллагуудын ажилтан алба хаагч нарт гамшиг осол болон гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр заавар, зөвлөмж өгч ажилласан байна.

“Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх” сэрэмжлүүлэг мэдээ мэдээлэл, анхааруулгыг иргэдэд хүргэх талаар сумдын Засаг даргын Тамгын газарт Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн албан мэдэгдлээр хүргүүлж, аймгийн “АВ”, “Тамир” телевизүүдээр тогтмол мэдээлж, Онцгой байдлын газрын цахим хуудсанд байршуулж, багц мессежээр малчдад хүргэн ажиллаж байна.

Эрдэнэбулган сумын нутаг дэвсгэрт байрлах 10000 метр үерийн далан, суваг шуудуу, нүхэн гарц, инженерийн барилга байгууламжид аймгийн Онцгой байдлын газар, Хот тохижилтын газар хамтран үзлэг шалгалт зохион байгуулж аюулгүй байдлыг хангаж ажилласан байна.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх болон үер, усны осол, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор Онцгой байдлын газраас амралт, зугаалгаар иргэд олноор очдог Булган

сумын нутаг Урд Тамирын гол Сангийн толгойн гүүрнээс доош Цэнхэр сумын гүүр хүртэл 20 км, Хойд Тамирын гол, Ихтамир сумын гүүрнээс доош явган болон завьт эргүүл ажиллуулж голын эргээр амарч буй 650 гаруй иргэнд үер усны ослоос урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгаа хийж, үерийн эрсдэлтэй газарт буусан 16 айл өрхөд мэдэгдэл өгч, санамж гарын авлага 195 ширхэгийг тарааж ажиллалаа.

Үндэсний баяр наадмын бүх нийтийн амралтын өдрүүдэд аймгийн Цагаан давааны замын постын цэгээр дамжин өнгөрч буй 50000 гаруй амрагч, аялагч, зорчигчдод коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, усны осол, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар санамж тараан ажилласан.

2021 оны 7-р сард аймгийн хэмжээнд өссөн дүнгээр 201 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 66, хулгайлах гэмт хэрэг 60, иргэдийн өмчийн хулгайн гэмт хэрэг 14, малын хулгайн гэмт хэрэг 31, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 9, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 56, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 22, гэмт хэргийн илрүүлэлт 34.1 хувьтай байна.

Нийт 11036 захиргааны зөрчил бүртгэгдсэнээс Зөрчлийн тухай хуулийн дагуу иргэнд 407370.6 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ 498.2 сая төгрөг, нөхөн төлүүлэлт 53.7 хувьтай байна.

Мэргэжлийн хяналтын газраас Засгийн газрын 2021 оны 118 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 41 дүгээр тушаалаар баталсан коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”, аймгийн Засаг даргын 2021 оны А/243, А/271, А/307, А/308 А/332 дугаар захирамжуудын хэрэгжилт, түр журмын тусгай нөхцөл шаардлагыг хангуулахаар үсчин гоо сайхан, хумс засал 8, нийтийн халуун ус, саун, бассейн 1, амралтын газар, жуулчны бааз 3, зочид буудал, дэн буудал 1, хүнсний авто тээвэр 2, хүнсний худалдааны төв 31, нийтийн хоол үйлдвэрлэл, хүргэлтийн үйлчилгээ 2, хүнсний бус бараа бүтээгдэхүүний зах, худалдааны төв 5, нийт 54 объектод хяналт шалгалт хийж, Бүрэн-Ар, Хасу, Мойлт, Хадат, Гост супермаркет, Тансаг трейд, Нэхий хүнсний худалдааны төв, Шим, Түшиг, Гост мини маркет зэрэг хүнсний худалдааны төв, дэлгүүрүүд нь ажилтан, үйлчлүүлэгчдийн биеийн халууныг хэмжээгүй, чийгтэй цэвэрлэгээг 2 цаг тутамд хийгээгүй зэрэг 30 зөрчлийг илрүүлж, 23 зөрчлийг газар дээр нь арилгуулж, зөвлөмж хүргүүлсэн байна.

Стандарт, хэмжил зүйн хэлтэст 7-р сард 7 аж ахуйн нэгж, 4 иргэний хүсэлт ирүүлснээс худалдааны газар-3, бүтээгдэхүүн-1, хоолны газар-1, жуулчины бааз-6, нийт-11 газрын үйл ажиллагаанд тохирлын үнэлгээ хийж, тохирлын гэрчилгээг нь сунгасан байна.

Улсын Онцгой комиссын 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 21 дүгээр хурлын тэмдэглэл, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 41 дүгээр тушаалаар баталсан түр журам, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежмент. коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед аюулгүй ажиллах ерөнхий зааварчилгаа MNS ISO/PAS 45005:2021 стандарт, аймгийн Засаг даргын 2021 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн А/304 дүгээр захирамжаар баталсан “Архангай аймгийн нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон бусад холбогдох журмын хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн Онцгой комиссын даргын тушаал, удирдамжийн дагуу Булган, Эрдэнэбулган, Цэнхэр, Өгийнуур, Ихтамир сумдын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын зориулалтаар байр сууцны үйл ажиллагаа

эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Стандарт, хэмжил зүйн хэлтэс хамтран хяналт шалгалт, зөвлөн туслах ажлыг 7 дугаар сарын 02-ны өдрөөс 14-ний өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. Хяналт шалгалт, зөвлөн туслах ажилд нийт 23 аж ахуйн нэгж, 22 иргэн хамрагдсан байна.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

Эрүүл мэнд

Эмнэлгийн байгууллагууд 551 ор, амбулаторийн 98 их эмчтэйгээр хүн амд үйлчилж давхардсан тоогоор 191 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсний 99.8 мянгад нь урьдчилан сэргийлэх үзлэг хийж 9.1 мянган хүнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчилж гаргасан байна. Вакцинжуулалтанд хамрагдвал зохих 0-2 насны хүүхдийн 94.5 хувийг бүрэн хамруулсны дотор Булган, Цэнхэр, Төвшрүүлэх, Өлзийт, Өгийнуур, Хашаат сумд 100 хувь хамруулсан байна.

2021 оны эхний 6 сард 887 эх төрж, 891 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 6.8 хувиар буюу 57 хүүхдээр их байна. Хүн амын нас баралт 199 гарсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 31 тохиолдлоор буюу 13.9 хувиар бага байна. Мянган хүнд ноогдох төрөлт 9.3 , нас баралт 2.1 ноогдож хүн амын ердийн цэвэр өсөлт 7.2 промил байна. Эхийн эндэгдэл 2 гарсан бол 1-5 насны хүүхдийн эндэгдэл 2, нялхсын буюу 0-1 насны хүүхдийн нас баралт 6 гарч мянган амьд төрөлтөд 6.7 ногдож байна.

Аймгийн дүнгээр арван мянган хүн тутмаас 174 нь буюу 1651 хүн халдварт өвчнөөр өвчилсөн байгаа бөгөөд Эрдэнэбулган 357, Хашаат 283, Хайрхан 202, Хотонт 183 сумдад аймгийн дунджаас дээгүүр байна, бусад сумдад аймгийн дунджаас доогуур байна. Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 92 хувь нь коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын халдвараар, 4.4 хувь нь бэлгийн замын халдварт өвчнөөр, 1.2 хувь нь сүрьеэгээр, 1.3 хувь цусан суулгаар, 1.1 хувь нь бусад халдварт өвчнөөр өвчилсөн байна. Халдварт өвчний гаралт өнгөрсөн оны мөн үеийнхээс 9 дахин ихээр буюу 1471 тохиолдлоор нэмэгдсэн байна.

Соёл урлаг

Аймгийн Нийтийн номын сан улс орон даяар коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын халдварын тархалт нэмэгдэж, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан гэрээр ном олголтоор 2 уншигч 9 ирэгсэдэд 25 ном олгож, 25 ирэгсэдэд 100 ш тогтмол хэвлэлийг гэрээр олгож үйлчилсэн байна.

Номын сангийн МонКoнa үүлэн технологийн программд үндсэн фондын “300 нэр төрлийн 700 ширхэг номыг шивж, бар коджуулан, монголын уран зохиол салбарын 538 нэр төрлийн 1675 ширхэг номыг номын нэг бүрчилсэн бүртгэлд бүртгэж тавиурт байрлуулж уншлагад гаргахад бэлэн болгосон.

Аймгийн Хөгжимт драмын театр аймгийн “АВ” телевизтэй хамтран нийт уран бүтээлчдийг сурталчилан таниулах уран бүтээлийг ард иргэддээ хүргэх зорилгоор “Уран бүтээлчийн цаг” цуврал нэвтрүүлгийн 2, 3-р хэсгийг бэлтгэж орон нутгийн телевиз болон мэдээллийн цахим сүлжээгээр дамжуулан үзэгчдийн хүртээл болгож байна.

Мөн Ардын хувьсгалын 100 , аймаг байгуулагдсаны 98 жилийн ойд зориулсан баяр наадмын шинэ уран бүтээлийн хүндэтгэлийн тоглолтыг видео бичлэг болгон орон нутгийн телевизээр үзэгчдийн хүртээл болгосон байна.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал

2021 оны 7 дугаар сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхтэй хайгч 1389 иргэн бүртгэлтэй байгаагаас, 683 эмэгтэй байна.

Шинэ ажлын байр 583, үүнээс байнгын ажлын байр 310, улирлын ажлын байр 120, түр ажлын байр 153 байна. Ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга 503, зуучлал 481 байна. 2021 оны 7 дугаар сарын 8-ны байдлаар 10 иргэн шинээр бүртгүүлж, LMIS программд шивж оруулсан.

Ажил идэвхитэй хайгч иргэдийг боловсролын түвшингээр нь ангилбал, боловсролгүй 13, бага 71, суурь 250, бүрэн дунд 815, техникийн болон мэргэжлийн анхан шатны 29, тусгай мэргэжлийн дунд 29, дипломын, бакалаврын 182 иргэнийг тус тус бүртгэж, мэдээллийн бааз үүсгэн ажилласан.

Нийгмийн даатгалын санд 2021 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар нийт 11.5 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 117.6 хувиар биелүүлсэн байна. Давхардсан тоогоор 16.2 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардалд нийт 1.2 тэрбум төгрөг зарцуулжээ. Улсын төсвөөс 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн тэтгэвэрт 3020.3 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд шилжүүлжээ.

Нийгмийн даатгалын санд 2021 онд 11.5 тэрбум төгрөгийн сангийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.2 тэрбум төгрөгөөр өссөн.

Ажил олгогч, даатгуулагчаас төлсөн шимтгэлийн орлогыг дараах байдлаар нийгмийн даатгалын сангуудад хуваарилсан байна. Үүнд, Тэтгэврийн даатгалын санд 65.3% буюу 8109.9 сая төгрөг, Тэтгэмжийн даатгалын санд 7.4 % буюу 682.9 сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын санд 5.6 % буюу 366.5 сая төгрөг, Ажилгүйдлийн даатгалын санд 1.6 % буюу 143.3 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын санд 20.1 % буюу 1564.4 сая төгрөг хуваарилсан байна.

2021 оны 7 дугаар сард нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардалд нийт 36.6 тэрбум төгрөг зарцуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад сангийн зардал 2.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

2021 оны 7 дугаар сард тэтгэврийн даатгалын санд 16542 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, улсын төсвөөс 24140 сая төгрөгийг тэтгэврийн даатгалын санд хүлээн авсан. Тус сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, цэргийн тэтгэвэр авагч 15.1 мянган иргэдийн тэтгэвэрт 32.9 тэрбум төгрөг зарцуулжээ. Нийт 81.7 хувь буюу 26.9 тэрбум төгрөгийг өндөр насны тэтгэвэр авагч 13.9 мянган иргэнд зарцуулсан байна.

2021 оны 1 дүгээр сарын 01-нээс эхлэн тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг ажил олгогч, даатгуулагч бүр 1 функтээр нэмэгдүүлэн, шимтгэлээ тооцож төлж байсан бол 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 1 функтээр буурсныг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг хэрэгжилтийг зохион байгуулан ажил олгогч, түүнд ажиллагсад 469.5 сая төгрөгийн, сайн дурын даатгуулагчдад 341.8 сая төгрөгийн чөлөөлөлтийг бүртгэсэн байна.

Гэр бүл, хүүхэд, залуучууд

Хүүхдийн тусламжийн 108 утаснаас шилжиж ирсэн 5 дуудлага мэдээллийг хүлээн авч холбогдох сум, байгууллагад шилжүүлэн шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна.

“Хүн бүр хүүхэд хамгаалагч” аяныг 6 дугаар сарын 25-наас 9 дүгээр сарын 25-нийг хүртэлх хугацаанд зохион байгуулж байгаа бөгөөд аяны хүрээнд гол усны, ахуйн, гал түймрийн аюул осол болон хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах, хүүхдэдээ тавих хараа хяналтаа сайжруулах, коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар сурталчилсан мэдээллийн том самбарыг 7 чиглэлд байрлуулж, аюул ослоос урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг хүргэсэн.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

Мал аж ахуй

Архангай аймгийн хэмжээнд 2021 онд төллөвөл зохих 1983.6 мянган толгой эх мал тоологдсоноос 85.3 хувь буюу 1855.3 мянган толгой эх мал төллөж 1738.1 мянган толгой төл малыг 94 хувьтай бойжуулсан.

Үүнээс нийт төллөвөл зохиох эх малыг төрөл тус бүрээр авч үзвэл нийт ингэний 68.8 хувь буюу 236 толгой ингэ, нийт гүүний 82.3 хувь буюу 81.4 мянган толгой гүү, нийт үнээний 81.7 хувь буюу 160.8 мянган толгой үнээ, нийт эм хонины 96.1 хувь буюу 1080.2 мянган толгой эм хонь, нийт эм ямааны 94.5 хувь буюу 532.7 мянган толгой эм ямаа тус тус төллөсөн байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 01 дүгээр албан даалгавар, “Сэг, зэм устгах тухай” аймгийн Засаг даргын 2021 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн А/117 дугаар захирамжийн дагуу аймгийн хэмжээнд том малын зүй бус хорогдлоор нийт 101438 толгой мал хорогдсоноос 91860 малын сэг зэмийг устгалын нүхэнд цуглуулан булах болон шатаах аргаар устгаж, нийтийн эзэмшлийн талбай-78084 м², хашаа хороо-57933 м², өтөг бууц-13920м², худаг уст цэг-8582 м², бэлчээр-12670м² агуулах зоорь, түүхий эд агуулах зоорь- 3808м², устгалын цэг-12545м², нийт 190382 м² талбайд халдваргүйтгэлийн ажил хийгдсэн. Ажлын явц 90.5 хувьтай хийгдэж байна. Энэ ажлын хүрээнд 1899 хүн, 284 машин техник дайчлан ажилласан байна.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн санаачлагаар малын чанар үүлдэр, угсааг сайжруулах зорилгоор хэрэгжиж буй "Малчны хотноос-Эрүүл хүнс" хөтөлбөрийн хүрээнд мах, сүүний чиглэлийн болон сарлагын үхрийг нийлүүлж, мэргэжлийн мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжүүд, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоогоор дамжуулан аймгийн малын үржлийн бодлоготой уялдуулан зохион байгуулж байна. Үүнд, баруун бүсийн сумдад сарлаг, Эрдэнэбулган сумын бүсэд сүүний чиглэлийн үнээ, Төвшрүүлэх болон газар тариалангийн бүсийн сумдад махны чиглэлийн Сэлэнгэ үүлдрийн үхрийг тус тус нийлүүлж Малын удмын сангийн үндэсний төвтэй 5 жилийн хугацаатай, эргэн төлөгдөх нөхцөлтэй хамтран ажиллах гэрээ байгууллаа.

Газар тариалан

Архангай аймаг 2021 онд үр тариа 8703 га талбайд үүнээс улаан буудай 8403 га-д, арвай 100 га-д, овьёос 200 га-д, малын тэжээл 3300 га-д, тосны таримал 900 га-д, төмс 277.5 га-д, хүнсний ногоо 147 га-д, жимс жимсгэнэ 168.9 га-д нийт 13496.1 га талбайд тариалхаар төлөвлөж улаан буудай 9818 га-д, арвай 40.5 га-д, овьёос 241.9 га-д, тосны таримал 420 га-д, малын тэжээл 4080 га-д, төмс 278 га-д, хүнсний ногоо 147 га-д, жимс жимсгэнэ 82 га-д нийт 15107 га талбайд тариалалт хийж тариалалтыг 111.9 хувиар биелүүлээд байна.

Үр тарианы ургамлын тариалалтын чанарыг соёололтоор хүлээн авсан дүнгийн нэгтгэлийг авч үзвэл 10400 га талбайд тариалснаас 2307 га буюу 22,8% нь соёололт онц, 5830 га буюу 57,7% нь сайн, 1963,4 га буюу 19,4% нь дунд зэргийн байна.

Үр тарианы соёололтын үед хур тундасны хэмжээ багасаж байсан бол сүүлийн өдрүүдэд үргэлжилсэн зөөлөн бороо орсноор хөрсний чийг сайжирч, ургамлын өсөлт хөгжилтөд сайнаар нөлөөлөөд байна.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Барилга, дэд бүтэц, газар

Архангай аймагт 2021 ийг үеэс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 171 тэрбум 866.2 сая төгрөгийн өртөг бүхий 69 төсөл арга хэмжээний захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. 2021 оны 7 дугаар сард дараах барилгын ажил эхэлсэн бөгөөд 23 барилгад үе шатны хяналт хийсэн. Үүнд:

Булган сумын Соёлын төвийн барилгын ажил, гүйцэтгэл 80%

Жаргалант сумын Соёлын төвийн барилгын ажил, гүйцэтгэл 50%

Хашаат сумын Сургуулийн өргөтгөлийн барилгын ажил, гүйцэтгэл 60%

Чулуут сумын 320 суудалтай сургуулийн барилгын ажил, гүйцэтгэл 90%

Эрдэнэбулган сумын 3-р сургуулийн Урлагийн заалны барилгын ажил, гүйцэтгэл

100%, ашиглалтад орсон.

Өндөр-Улаан сумын Хануй багийн бага сургуулийн барилгын ажил, гүйцэтгэл 70%

Цахир сумын Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, гүйцэтгэл 100%, ашиглалтад орсон.

Булган сумын Сургуулийн барилгын засвар тохижилтын ажил, гүйцэтгэл 60%

Шинээр 4 барилгын ажлын гэрээ байгуулж, 2022 онд хэрэгжих 5 барилгын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан.

Мөн Цахир сумын 50 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, Эрдэнэбулган сумын 1-р сургуулийн дотор халаалт, цэвэр ус хангамж, ариутгах татуургын шугам солих ажил, Хангай сумын Соёлын төв, спортын заалны их засварын ажилд улсын комисс ажиллуулж ашиглалтад хүлээн авсан байна.

2021 оны 7 дугаар сард аймгийн Засаг даргын газартай холбоотой 42 захирамж гарч, 93 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл хүсэлтийг шийдвэрлэсэн байна.

Мөн тайлант хугацаанд төрийн 2, гэр бүлийн хэрэгцээний 75, аж ахуйн нэгж, байгууллагын 12, нийт 89 гэрчилгээнд бичилт хийж, 475000 төгрөг, 178 ш кадастрын зургийн үнэт цаасны төлбөрт 890000 төгрөг, 89 ш гэрчилгээн дээр бичилт хийсний улсын тэмдэгтийн хураамжид 1098000 төгрөг, мэдээллийн сан үүсгэсний төлбөрт 305120 төгрөгийг тус тус төсөвт төвлөрүүлсэн байна.

-----oOo-----